



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/423

Ховд

«Бэлчээрийн даац, багтаамжийн судалгааны»
ажлыг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “А” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 286 дугаар тогтоолыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд бэлчээрийн төлөв байдлын ажиглалт, даац, багтаамжийн судалгааг жил бүрийн 8 дугаар сарын 10-13-ны хооронд, өвлийн бэлчээрийн явуул судалгааны ажиглалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 20-23-ны хооронд батлагдсан аргачилал, зөвлөмжийн дагуу холбогдох ажлын хэсгийг томилон чанартай хийж, гүйцэтгэн ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Монгол орны бэлчээрийн үндэсний судалгааны ажлын хүрээнд аймгийн бэлчээрийн даац, багтаамжийн дүн мэдээг нэгтгэн ирүүлэхийг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга /А.Энхзаяа/-д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, цаг тухай бүрт танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН